



Хөвсгөл”Сумын эрүүл мэндийн
төв хөгжлийн түлхүүр” ТББ



Дэлхийн банк



Хөвсгөл аймгийн Эрүүл
мэндийн газар

ТӨСЛИЙН ТЕХНИКИЙН ЗӨВЛӨХ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗАР

Төслийн нэр: ДЭЛХИЙН БАНКНЫ САНХҮҮЖИЛТЭЭР ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ХЭРЭГЖҮҮЛЖ БУИ “Монгол улсад КОВИД 19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төслийн хүрээнд Хөвсгөл аймагт хэрэгжих “Маанар” төсөл

ҮНДЭСЛЭЛ: ГАЗАР НУТАГ, ХҮН АМ ЗҮЙН ОНЦЛОГ

Хөвсгөл аймаг 100,6 мянган кв.км газар нутагтай, ОХУ, Булган, Архангай, Завхан аймагтай тус тус хиллэдэг. Засаг захиргааны нэгжийн хувьд 23 сум, 1 тосгон, 127 багтай. Хөвсгөл аймгийн хот хоорондын замын дагуу Тариалан, Их-Уул, Тосонцэнгэл сумдаас бусад 20 сум шороон замтай, бартаа саад ихтэй, Улаанбаатараас 1100-1400км, Аймгийн төвөөс 130-295 км зайд алслагдан оршдог. Цаг агаарын хувьд өвөлдөө 40-45 хэм хүрч хүйтэрдэг, зундаа нэмэх 25-30 хэм хүртэл халдаг эрс тэс уур амьсгалтай, алслагдсан байршилтай аймаг билээ.

Тус аймаг нь 39,449 өрхтэй, 136.0 мянган хүн амтай бөгөөд бусад аймгуудтай харьцуулахад хамгийн их хүн амтай, өвөрмөц ёс заншил, шашин шүтлэг, амьдралын хэв маяг ялгаатай олон ястнууд амьдардаг онцлогтой. МААНАР төсөл Хөвсгөл аймгийн цаатан иргэд, дархад ястан алслагдсан бүс нутагт амьдардаг Цагааннуур, Баянзүрх, Улаан-уул, Рэнчинлхүмбэ сумдад хэрэгжихээр төлөвлөөд байна.

Дэлхий нийтийг хамарсан КОВИД-19 цар тахлын халдвар Хөвсгөл аймагт 4 удаа эрчимтэй дэгдсэн.

Дархад, цаатан ястан бүхий 4 сумын байдлыг авч үзвэл Баянзүрх сум-562 буюу хүн амын 13,8%, Рэнчинлхүмбэ сум – 509 буюу 10.4%, Цагааннуур сум -76 буюу 3,7%, Улаан-Уул сум 485 буюу 11,2% нь тус тус Ковид 19 халдвараар өвчилсөн байна. Өвчлөлөөс хүндэрч нас барсан тохиолдол Баянзүрх -1 буюу 0,17%, Улаан-Уул -1 тохиолдол буюу 018%, Рэнчинлхүмбэ нас баралтгүй, Цагааннуур 1 тохиолдол буюу 1.03% эзэлж байгаа ба Цагааннуур сумын хувьд өвчлөл бага бүртгэгдсэн хэдий ч нас баралтын тохиолдол байгаа нь хариу арга хэмжээний чанартай холбоотой байхыг үгүйсгэхгүй.

КОВИД-19 халдварын тохиолдол өнөөг хүртэл үргэлжлэн илэрч, бүртгэгдсээр байгаа ба цаашид дахин дэгдэлт үүсэх, бусад шинэ болон шинээр сэргэн тархах халдварын тохиолдол үүсэж нийгмийн эрүүл мэндэд ноцтой аюул занал тулгарвал эрүүл мэндийн салбарын ачааллыг бууруулахад иргэдийн өөрийгөө болон бусдыг хамгаалах зөв мэдлэгтэй байх, дадал хандлагад суурилсан үүрэг хариуцлага хяналт, сайн дурын оролцоо дэмжлэг чухал байна.

Нөгөө талаас эрүүл мэндийн ажилтнуудын өөрсдийн мэдлэг ур чадвар дутах, ачаалал ихээс шалтгаалж мэдээлэл сургалт зөвлөгөө хүргэх боломж хомсдох, газар нутгийн алслагдсан байдал, эрүүл мэндийн үнэн зөв мэдээллийг шуурхай тогтмол авах хэрэгцээ хангагдахгүй зэрэг тулгамдсан асуудлууд байна. Ийм учраас иргэд цахим орчин болон танил найз нөхөд, гэр бүл, хүн хоорондын ярианаас баталгаа нотолгоогүй мэдээлэл авч буруу мэдлэг дадалтай болж улмаар эмч эмнэлгийн ажилтанд итгэхгүй болох эрсдэлтэй байна.

Газар нутгийн алслагдсан байдал, мэдээлэл хомс байдлаас шалтгаалан шинжлэх ухааны үндэслэлтэй, нотолгоонд суурилсан мэдээлэл авч чаддаггүй, ихэвчлэн ам дамжсан нотолгоогүй мэдээлэл түгэх эрсдэл бүхий сум, багуудыг сонгож, олон нийтийн шинэ болон шинээр сэргэж буй халдварын урьдчилан сэргийлэх, эрүүл мэндээ хамгаалах мэдлэг дадлыг дээшлүүлэх нэн чухал байна.

“МААНАР” төслийн үйл ажиллагааны хэрэгжилт дүн шинжилгээ хийж төслийг хэрэгжүүлэх явцад гарч буй алдаа, бэрхшээлийг даван туулах арга замыг хамтран шийдвэрлэх, төсөл хэрэгжүүлэхэд ашиглах шинэлэг арга хэрэгслийг зааж сургах ялангуяа олон нийтийн болон орон нутгийн удирдлага эрүүл мэндийн төвүүдийн эрэлт хэрэгцээ онцлогт тохирсон арга аргачлал, мэдээллээр хангах, үр дүнг үнэлэх, зөвлөн туслах зорилготой зөвлөх ажиллах шаардлага байна.

Зөвлөх шалгаруулах зорилго: Шинэ болон шинээр сэргэж буй халдварт өвчний үеийн болон дараах эрсдэлээс хамгаалах урьдчилан сэргийлэх, хамгаалах мэдээлэл харилцааны чиглэлээр аймгийн төслийн баг болон сонгосон сумдын хэрэгжүүлэгч нар, олон нийт, удирдах ажилтан, эрүүл мэндийн ажилтнуудыг тэдний эрэлт хэрэгцээ онцлогт тохирсон хамтран ажиллах, оролцох, олон нийтийг идэвхжүүлэх арга аргачлал мэдээллээр хангах, үр дүнг үнэлж зөвлөх, төсөлд оролцогч талуудыг гэрээний шаардлагын дагуу үйл ажиллагааг үр дүнтэй хамтран хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх техникийн зөвлөх ажиллуулах

Зөвлөх-д тавигдах шаардлага:

Боловсрол:

- Зөвлөх нь Магистр болон түүнээс дээш зэрэгтэй /холбогдох чиглэлээр магистр, докторын зэрэгтэй бол давуу тал болно/
- Нийгмийн эрүүл мэнд, сэтгүүл зүйн чиглэлээр суралцсан

Ур чадвар, Туршлага

- Нийгмийн эрүүл мэнд болон олон нийттэй ажиллах чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх /эрсдэлийн мэдээлэл харилцаа, нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл сургалт сурталчилгаанд

олон нийтийг оролцуулах, идэвхижүүлэх чиглэлээр ажилласан бол давуу тал болно./.

- Эдгээр ур чадвар болон ижил төстэй төсөл амжилттай хэрэгжүүлсэн байх
- Судалгааны арга зүйн талаар мэдлэгтэй, тоон анализ хийх ур чадвартай байх
- Зарчимч, өндөр хариуцлагатай, багаар ажиллах чадвартай
- Компьютерийн өргөн хүрээний мэдлэгтэй
- Нийгмийн эрүүл мэндийн судалгаа болон эрсдэлийн үнэлгээ хийж дүн шинжилгээ хийх чадвартай
- Яриа болон бичгийн англи хэлтэй / холбогдох бичиг баримт сертификатаар баталгаажсан/ давуу тал болно
- Орон нутгийн удирдлага, хамт олонтой ажиллаж байсан туршлагатай, албан бичиг боловсруулах чадвартай байх
- Бичгийн болон ярианы англи хэл дээр тайлан бичиж байсан туршлагатай, чадвартай байх
- Харилцааны өндөр чадвартай, илтгэх ур чадвартай
- Зохион байгуулах, багаар ажиллах чадвартай
- Хувийн зохион байгуулалт сайтай, цагийг зөв удирдах чадвартай
- Зайнаас ажиллах ур чадвар, туршлагатай
- Бусад аймаг сумдад аялал хийх боломжтой байх

Сонирхсон этгээд Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газрын khuvsqul.emg@gmail.com и-мэйл хаяг руу сонгон шалгаруултанд оролцох тухай хүсэлт илгээж дэлгэрэнгүй мэдээлэл, бүрдүүлэх материал болон ажлын даалгаврыг авна уу.

Техникийн зөвлөх дараах үүргийг гүйцэтгэнэ:

- Төслийн багийнхны үйл ажиллагаатай танилцаж мэдээлэл зөвлөгөө өгөх
- Төслийн багийг олон нийттэй ажиллах болон, тэднийг сургахад ашиглах аргачлал аргагүйгээр хангах
- Мэдээлэл харилцааны баримт бичиг, төлөвлөгөө боловсруулах болон мэдээлэл сургалт сурталчилгааны гарын авлага бэлтгэхэд зөвлөгөө өгөх
- Мэдээлэл харилцааны үйл ажиллагаа хэрэгжүүлэх явцад учирч буй саад бэрхшээлийг даван туулахад дэмжлэг үзүүлэх
- Англи/ Монгол хэл дээр тайлан бичихэд дэмжлэг үзүүлэх

Оролцогчийн сонгон шалгаруулалттай холбоотой материалыг хүлээн авах сүүлийн хугацаа:

2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 16:00 цаг хүртэл хүлээн авах болно.

Сонгон шалгаруулалтад оролцогчийн бүрдүүлэх баримт бичиг:

Сонгон шалгаруулалтад оролцогч нь тавигдах шаардлагыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг бүрдүүлж ирүүлнэ. Үүнд;

1. Төрийн албан хаагчийн анкет болон CV;
2. Мэргэжлийн диплом, мэргэшлийн болон зэргийн үнэмлэхийн хуулбар;
3. Иргэний үнэмлэхийн хуулбар;
4. Ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчилд холбогдоогүй талаар ажиллаж буй албан байгууллагын тодорхойлолт;
5. Туршлага, ур чадвар, ёс зүй харилцаа хандлага, манай төсөлтэй ижил төстэй төсөл арга хэмжээ хэрэгжүүлсэн туршлага, ур чадварыг тодорхойлсон 2 захидал ирүүлэх

Сонгон шалгаруулалтын үнэлэх хэлбэр:

Материалын бүрдүүлэлт, боловсрол, мэргэжил дээшлүүлсэн байдал, туршлагын анкет, ирүүлсэн бичиг баримтад тулгуурлан үнэлнэ.

Материал хүлээн авах хаяг: Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 8 дугаар баг Аймгийн Эрүүл мэндийн газрын байр 204 тоот, Цахим хаяг: Khuvsgul.emg@gmail.com

Лавлах утас: +976-88068400, +976-88018049, +976-70383586

Хөвсгөл аймгийн "Сумын эрүүл мэндийн
төв хөгжлийн түлхүүр"ТББ